

ТОО ЦИФРИЙГ ЭНГИЙНЭЭР, ТОДОРХОЙ БУСЫГ БАРИМТААР...

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангуудад хийсэн харьцуулсан ажиглалтаас

Үүсэл, учир шалтгаан

Монголыг уул уурхай тэжээж байна гэж ярьдаг. Гэхдээ баримт нь хаана байна? Яг үнэндээ манай улсын экспортын 70 гаруй хувийг алт, зэс бүрдүүлдэг гэхээс өөр тоо баримтыг мэддэг хүн ховор байдаг. Тэгвэл уул уурхайн компаниудаас улсад хэдэн төгрөг төлдөг хэрэг вэ?

Тэд ийм тийм татвар, хандив тусламж өглөө гэж нутгийн иргэдэд ярьдаг нь үнэн эсэхийг яаж шалгахав, нөгөө талаас компаниудын өгсөн татвар, төлбөр төрийн дансанд орж байна уу, буруу замаар явчихаж уу гэдгийг ч мэдэх эрх олон түмэнд байх ёстой. Үүнийг мэдэж байна гэдэг нь ард түмэн байгалийн баялагтаа эзэн байх, түүнийг хянах анхдагч нөхцөл юм.

Яг ийм логикоор байгалийн баялаг арвин улс орнуудад “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага” (ОУИТБС) сүүлийн жилүүдэд хэрэгжиж байгаа юм. Энэ санаачлагын үндсэн зарчим ёсоор нэг талаас уул уурхай, газрын тосны компаниуд тухайн жилд хэнд ямар татвар, төлбөр, хураамж, хандив төлснөө олон нийтэд мэдээлэх, нөгөө талаас засгийн газар тэдгээрээс авсан бүхнээ тайлагнах бөгөөд хоёр талаас гаргасан тайланд хөндлөнгийн этгээд бие даасан аудитын дүн шинжилгээ хийдэг. Эндээс зөрүү гарвал чухам юунаас болсныг тодруулна, хэрэв авилга, хууль бус үйлдэл байгаа бол дахин гаргахгүй байх ажлыг тал бүрээс хийнэ.

Ил тод байдал, байгалийн баялгийн менежмент, ард түмний ашиг хүртэх боломжийг сайжруулах энэ санаачлагад манай улс 2006 онд нэгдэн орж 3 удаагийн тайлан гаргаад байгаа юм. Нийт 33 улс оронд хэрэгжиж байгаа энэхүү санаачлагад нэгдэн орсон улс орнууд баталгаажуулалт хэмээх хөндлөнгийн үнэлгээ хийлгэх учиртай нь нэг ёсны чанарын баталгаа гаргах явдал юм. Монгол улс ч уг баталгаажуулалтыг 2010 онд хийлгэж, 2010 оны 10 дугаар сард санаачлагыг хэрэгжүүлэхээр “нэр дэвшигч” улс орны ангиллаас тус санаачлагын үзэл баримтлалыг “бүрэн даган мөрдөгч” болсныг ОУИТБС-ын Олон улсын зөвлөлөөс зарлажээ. Дээрх 33 орноос одоогоор 5 улс нь ийм статустай байгаа нь тус санаачлага Монгол улсад хэрэгжээд тодорхой үр дүнд хүрч байгаагийн илрэл биз. Гэхдээ Монгол улс тус санаачлагыг хэрэгжүүлсэний жинхэнэ утга учир нь уул уурхайгаас орох орлого иргэдэд хүрсэн үр дүнгээр илрэх нь тодорхой тул цаашид иргэддээ санаачлагын талаар цогц, ойлгоход хялбар дөхөм мэдээлэл хүргэхэд төр засгаас онцгой анхаарах шаардлагатай байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд Монгол улс 2006-2008 оныг хамарсан гурван удаагийн тайлан бэлтгэн гаргасан ба 2009 оны тайланг бэлтгэн гаргах ажил ид дундаа явж байна. Тайлангуудын талаарх ерөнхий тоон мэдээллийг хүснэгтэнд үзүүлэв. Санаачлагын тайлан бэлтгэгддэг шат дамжлагыг товчхон тайлбарлая. Компаниуд (3-р багана) тухайн санхүүгийн жилд (1-р багана) улсад төлсөн татвар, төлбөр, хураамж, бусад хандив тусламж зэргийн талаарх мэдээллийг тус тусдаа гаргаж, ОУИТБС-

ын ажлын хэсэгт хүргүүлдэг. Мөн Сангийн яам уул уурхайн компаниудаас авсан татвар, төлбөр, хураамж, бусад хандив тусламж зэргийн талаарх мэдээллийг (4-р багана) мөн гаргаж, ажлын хэсэгт хүргүүлдэг. Эдгээр тайланг хүлээн аваад тодорхой босго үнээс (5-р багана) их төлбөр төлсөн компаниудын тайланг хөндлөнгийн аудитын байгууллага нягтлан үзэж, Монгол улсын ОУИТБС-ын тайланг бэлтгэн гаргадаг. Ингэхдээ тэд компаниуд, засгийн газрын ирүүлсэн тайлангийн хооронд гарч буй анхдагч зөрүү (6-р багана)-г нягтлаад, учир шалтгааныг нь олж, харин тайлбарлаж чадаагүй зөрүүг (7-р багана) эцсийн тайланд тусгадаг. Цаг хугацааны хувьд тайлангууд нилээд хожуу гарч байгаа нь (8-р багана) анхаарал татсан асуудал юм.

Тайлангийн жил	Аудитад хамруулсан компанийн тоо	Тайлан гаргасан компанийн тоо	Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоо	Тайланд хамруулах төлбөрийн босго	Анхдагч зөрүү	Тайлбарлагдаагүй зөрүү	Тайланг гаргасан огноо
2006	25	97	137	100 сая	96.8 тэрбум	25 тэрбум	2007 оны 7-р сар
2007	38	102	186	200 сая	141.4 тэрбум	11.6 тэрбум	2009 оны 9-р сар
2008	46	115	184	100 сая	47.1 тэрбум	1.1 тэрбум	2010 оны 7-р сар
2009 (гараагүй байгаа)	48	125	363	сая төгрөг			

Дээрх хүснэгтэнд танилцуулсан мэдээллийг илүү дэлгэрүүлж авч үзье.

Оролцоо, хандлага

2006 он

Нийт 97 компани тайлангаа ОУИТБС-ын Ажлын албанд¹ ирүүлжээ. Харин Сангийн яам 137 компаний тайланг нэгтгэж ирүүлснээс 100 сая төгрөгөөс дээш татвар төлсөн 25 компанийн тайланг Засгийн газрын мэдээлсэнтэй харьцуулан аудитад хамруулсан.

Эхний жилд дээрх 25 компанийн төлсөн гэх татвар, төлбөр Засгийн газрын тайлагнаснаас 25 тэрбум төгрөгөөр илүү гаран зөрж багагүй шуугиан болж байсан юм. Аудитыг гүйцэтгэсэн Австралийн Крэйн Вайт АссошиэТС компани зөрүүг нягтлан шалгаж зөрчлийг арилгах тооцоо хийхээс өмнө буюу анхан шатны харьцуулалтаар 96,8 тэрбум төгрөгийн зөрүү гарч байсан нь үнэхээр анхаарал татаж байв.

Анх удаа ийнхүү тайлан гаргахад уул уурхайн орлогын бүртгэл, хяналт сул байсан нь ихээхэн хэмжээний зөрүүг аудитор тайлбарлаж чадахгүй явдал илтгэнэ.

2007 он

Засгийн газрын тайланд 185 компанийг хамруулснаас 38-ыг аудитад хамруулж, компанийн өөрийн гаргасан тайлантай тоог нийлэв. Энэ удаад 11,5 тэрбум төгрөгийн зөрүү аудитын нэгтгэлээр шийдэгдээгүй өнгөрсөн, гэхдээ үүний 8,1 тэрбум нь зөвхөн Паушокийн буюу манай улсыг олон улсын арбитрын шүүхэд өгөөд байгаа “Алтандорнод” ХХК болон “Туншин” хэмээх жижиг компанитай холбоотой байжээ.

Анхан шатын харьцуулалтаар зөвхөн татвараас 32 тэрбум төгрөгийн зөрүү гарсан нь залруулгаар 8 тэрбум болж буурсан байдаг. Тухайн жилд аудитыг “Эрнст энд Янг” компани гүйцэтгэжээ. Он дамжуулсан төлбөрийг Засгийн газар, эсвэл компани буруу онд нь тайлагнадаг, татварын нэр төрлийг ялгахгүйгээр нэгтгэн тайлагнадаг, хандив тусламж зэргийг төрийн байгууллагууд бүртгэдэг тогтолцоо байхгүй зэрэг нь аудитын байгууллага ч тайлбарлаж чадахгүй зөрүү гарахад нөлөөлсөн байна.

2008 он

Засгийн газар 184 компанийн мэдээллийг нэгтгэн ирүүлснээс 46 компанийг аудитад хамруулсан байна. Анхан шатны аудитаар 47,1 тэрбум төгрөгийн зөрүү анхан шатанд гарсныг Монголын Улаанбаатар аудит, Харт Нойрс компанудын хамтарсан баг 1,1 тэрбум төгрөг болгож бууруулж чадсан бөгөөд эндээс байгаль хамгаалахтай холбоотой зардлын зөрүүг хасвал “ердөө л” 420 сая төг ямар нэг тайлбаргүйгээр дутжээ.

2006 онд 1 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төлбөр төлсөн 10 компани байсан нь 2007 онд 17 болж нэмэгдсэн бөгөөд 2008 онд эдийн засгийн хямрал дээд цэгтээ хүрч уул уурхайн орлого нийт дүнгээрээ буурсан ч гэлээ тэрбумаас ихээр төлдөг томчуудын тоо хэвээрээ байжээ.

2009 он

Засгийн газар нийт 363 компанийн мэдээллийг нэгтгэн гаргасан. Нөгөө талаас 129 компани өөрсдийн санхүүгийн мэдээллийг ирүүлсэн нь хамрах хүрээний хувьд нэмэгдсэн. Харин тайлангуудыг ирүүлж буй цаг хугацааны хувь учир дутагдалтай хэвээр байна. Үүний

¹ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын алба

улмаас 2010 он дуусч байгаа энэ үед 2009 оны санхүүгийн тайлангуудад аудит хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байгаа юм.

Зүй нь Ашигт малтмалын хуулийн 48-10 дугаар заалтын дагуу компаниудын тухайн жил борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл, улсын болон орон нутгийн төсөв төлсөн татвар, төлбөрийн мэдээлэл нь дараа оны 1 дүгээр улирал гэхэд нийтэд танилцуулагдсан байх учиртай.


Ийнхүү тайлан гарсан 4 жилийн хугацаанд хамрагдсан компаниудын тоо нэмэгдэж, харин зөрчил нь багасч байгаа сайн шинж тэмдэгүүд ажиглагдаж байна. Гэхдээ ашигт малтмал, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани энэ тайлангийн ач холбогдлыг ойлгож сайн дураараа тайлангаа гаргаж байна уу гэвэл үгүй юм.

2010 оны 10 дугаар сарын байдлаар манай улсад нийт 1918 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаа нь өмнөх онуудаасаа бараг 1000-р буурсан тоо². 2006 оны Ашигт малтмалын шинэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг иргэдэд олгохоо больж зөвхөн аж ахуйн нэгжид олгож байгаа учраас энэ тооны компани геологи, уул уурхайн салбарт ажиллаж байна гэсэн үг юм. Үүний 1/3 орчим нь ашигт малтмалын ашиглалтын лиценз эзэмшиж байна. Эндээс үзвэл оролцоо хамгийн өндөр байгаа 2009 оны байдлаар л гэхэд нийт лиценз эзэмшигч компаниудын 6.7 хувь ил тод байдлын тайлангаа гаргажээ. Энд хайгуулын болон, ашиглалтын компаниуд аль аль нь орсон байгаа.

Уул уурхайд найдсан төсөв


2008 оны байдлаар авч үзэж буй уул уурхайн чиглэлийн 184 компани нь бүх төрлийн татвар, төлбөр, хураамжийн төлбөрт улсын төсөвт 691 тэрбум 926.3 сая төгрөгийн орлого оруулсан нь тухайн оны төсвийн нийт орлогын 65.7 хувь болж байна. Манай бодлого боловсруулагчид уул уурхайн үйлдвэрлэлийг нэн чухалчилж, унаган байгаль, хүний эрүүл мэндээс ч илүүд үзэх болсны учир шалтгаан энэ байж болох юм.

**Олборлох компаниудаас хүлээн авсан нийт татвар,
төлбөр 2006-2008 онд /мян.төг/**



² Эх сурвалж: Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар

Гэхдээ 2008 оны дүн нь 2007 оноосоо 8 хувиар бага байгаа юм. Энэ нь тухайн жилд эдийн засгийн хямрал дээд цэгтээ хүрч ашигт малтмалын үнэ доогуур байсантай холбоотой.



Уул уурхай, олборлох салбарын төсвийн орлого бүрдүүлэлтийн энэхүү тоог Монгол улсын нийт татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн тоотой харьцуулбал ихээхэн сонин дур зураг ажиглагдаж байна. 2008 оны тоонуудыг жишээ болгон авч үзэхэд олборлох салбарын 184 компани улсын төсвийн татварын орлогын 36,5 хувийг бүрдүүлж байгаа бол бусад салбарын 43.597 (Нийт 43.781-184) аж ахуйн нэгж нийлээд үлдсэн хувийг бүрдүүлж байгаа болж таарч байна.

Эндээс үзвэл уул уурхайн болон газрын тосны компаниуд үндэсний нийт баялгийн ихэнхи хувийг ашиглаж, эндээс нэмүү өртөг бий болгодог болох нь харагдана. Үүнийг дагаад хөрөнгө оруулалт, ажиллах хүчний дийлэнхи нь нэг салбарт чиглэгдэж улмаар манай эдийн засгийн тулгуур бат бэх бус, нэг салбараас хэт хамааралтай байгаа гэсэн үг.

Улсын төсвийн орлогоос гадна нийт эдийн засагт уул уурхайн салбар давамгайлах байр суурь эзэлж буйг тоо баримтууд харуулж байна.

Макро эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувь ³					
Үзүүлэлтүүд	2004	2005	2006	2007	2008
<i>ДНБ, 2005 оны үнээр, тэрбум төгрөг</i>	2591,6	2779,6	3017,4	3325,8	3620,5
<i>Уул уурхай, олборлох үйлдвэрийн эцсийн нийт бүтээгдэхүүн, 2005 оны үнээр, тэрбум төгрөг</i>	550,1	608,2	654,1	757,4	795,5
<i>Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний ДНБ эзлэх хувь</i>	17,2	22,1	30,0	29,5	28,2
<i>Нийт экспорт, сая ам доллар</i>	869,7	1064,9	1542,8	1949,2	2534,5
<i>Эрдэс бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь</i>	40,7	42,7	57,9	66,8	60,3

³ Эх сурвалж: Үндэсний статистикийн газар


Дээрх график, хүснэгтүүдээс харахад уул уурхай Монголыг /үнэн хэрэгтээ улсын төсвийг/ тэжээж байна гэдэг үг үнэний ортой харагдаж байна. Стратегийн томоохон ордуудын ашиглалт шуударсан тул энэ хувь хэмжээ цаашид ч нэмэгдэх магадлалтай байна.

Ийнхүү нэг салбараас бүр тодруулбал 1-2 бүтээгдэхүүнээс улсын төсөв, нийт эдийн засаг өндөр хамааралтай үед орлогын менежментийн оновчтой сайн тогтолцоо чухал шаардлагатай байдаг. Манай улсад ийм тогтолцоо үгүйлэгдэж байгаа нь анзаарагддаг.

Юунаас мөнгө олж байна вэ?

Уул уурхайн компаниуд ард түмний мэдлийн шавхагдах нөөц баялгийг ашигласны хариуд гарч байгаа ашиг хонжоо нь юун түрүүн тухайн салбарыг эдийн засагт оруулж байгаа санхүүгийн урсгалаар тооцогдоно. Ажлын байр харьцангуй багаар бий болгодог, хөрөнгө их шаарддаг тул гадны хөрөнгө оруулагчид түлхүү орж ирсэнийг нь бодвол Монгол улсын эдийн засагт нөлөөлөх байдал улсын төсөвт оруулж байгаа хувь нэмрээр илүүтэйгээр үнэлэгдэнэ. Тэгвэл тус салбараас улсад орж байгаа орлогын бүтэц ямар байна вэ гэдгийг ОУИТБС-ын тайлангийн ачаар баялгийн жинхэнэ эзэд болох олон нийт мэдэх боломжтой болж байна.

2008 онд Засгийн газрын хүлээж авсан
нийт орлогын бүтэц



Эндээс үзэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, онцгой албан татвар, автобензин дизелийн түлшний албан татвар, авто тээврийн хэрэгслийн албан татвар, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар гэсэн 7 төрлийн татвар дээр нэмээд ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрлийн төлбөр, нөөц ашигласны төлбөр нийлээд нийт орлогын 95 хувийг бүрдүүлж байна.

Харин төрийн өмчийн ноогдол ашиг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу засгийн газарт төлж буй төлбөрийн хувь хэмжээ ихээхэн бага харагдаж байна.

Ялангуяа 2008 онд бүтээгдэхүүн хуваах гэрээний төлбөр огт бүртгэгдээгүй байгаа нь энэ талын тайланг гаргаж өгөх ёстой АМГТХЭГ-ын алдаа юу аль эсвэл аль эртнээс туршилтын нэрээр олборлолт явуулж их, бага хэмжээний төлбөр төлж байсан “Петрочайна дачин тамсаг”, “Доншин газрын тос” зэрэг компаниуд бүтээгдэхүүн хуваах гэрээний төлбөрөө төлөхөө больчихов уу гэдэг нь ойлгомжгүй байна.

Хамгийн ихээр төлсөн компаниуд

2006 он

	Компани	Татвар, төлбөр /төгрөгөөр/
1	Эрдэнэт	370,889,288.92
2	Цайртминерал	5,893,147.31
3	Бороогоулд	5,208,579.25
4	Шижир-Алт	4,659,014.35
5	Тавантолгой	4,459,730.59
6	Алтандорнод монгол	3,879,752.40
7	Багануур	3,558,064.90
8	Гацуурт	2,054,922.09
9	Айвенхоу Майнз Монголия Инк	1,558,945.60
10	Шивээ-Овоо	1,039,242.42

“Бороо гоулд” компани 2006 онд 5,2 тэрбумыг төлсөн нь багагүй мэт харагдаж байгаа боловч үүний ердөө 91 сая нь татвар, бусад нь төрөл бүрийн төлбөрүүд байжээ. Харин дараа жил нь буюу 2007 оны 8 дугаар сард тогтвортой байдлын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гэнэтийн ашгийнхаас бусад бүх төрлийн татварыг бусдын нэгэн адил төлөх болсноор 37.6 тэрбум төгрөгийн татвар төлөх болсон байна.

2007 он

1	Ýðäýí ýò	599,522,391.40
2	Áíðííáíóëä	46,666,239.56
3	Àëòáíáíðííä ìííáíë	29,201,697.40
4	Òààáíòíëáíé	10,864,071.90
5	Ì àòðí÷àéí à äà÷èí òàì ñàä	8,723,500.00
6	Öàéðòì èí äðäë	8,427,576.30
7	Ýðäì èí	7,215,911.30
8	Àéááíòíó ì áéíç ìííáíëèý èíé	5,816,771.25
9	Øèæèð-Àëò	4,487,932.80
10	Ì ííáíëðíñòáàòì àò	3,069,187.19

2007 онд “Петрочайна дачин тамсаг”-ийн 7.69 тэрбумын бүтээгдэхүүн хуваах гэрээний төлбөрийг хасвал бусад үндсэн татвар, төлбөрөөрөө эхний 10 байтугай 20-д ч сураггүй байжээ. Харин оронд нь Гацуурт компани 2 тэрбум төгрөгийн татвар, төлбөрөөр эхний 10-г орж ирнэ.

2008 он

1	Ýðäýí ýò	549,630,714.36
2	Áíðííáíóëä	29,694,133.25
3	Òààáíòíëáíé	18,545,020.83
4	Öàéðòì èí äðäë	18,052,386.37
5	Àëòáíáíðííä ìííáíë	10,628,507.60
6	Áíëä ò°ì °ð äð°° áíë	6,808,528.35
7	Ì ííáíëýí Àëò ì áë	5,508,006.37
8	Ýðäì èí	5,250,304.90
9	Øèæèð-Àëò	4,505,023.48
10	×èíòóà ì áë í äðëéí ñòáàéò	4,246,123.32
11	Ì ííáíëðíñ-òáàòì àò	4,182,368.18

Улсад юу ч төлөөгүй боловч уурхайн ордтой компаниуд

Үнэмшмээргүй боловч ийм компаниуд цөөнгүй байдаг ажээ. Ямар нэгэн татвар огт төлөөгүй боловч лицензийн төлбөр төлөөд байсан компаниуд жил бүрийн тайланд орсон байгаа нь анхаарал татаж байсан юм. Тэднээс 2008 оны байдлаар 0 төгрөгийн татвар төлсөн 10 компанийг сонгож аваад АМГТХЭГ-лицензийн мэдээллийн сангаас шүүж үзэхэд тэд бүгд хаа нэг газар ашигт малтмалын ашиглалтын лицензтэй байх юм. Гэсэн хэрнээ улсад нэг ч төгрөгийн татвар төлөөгүй гэсэн үг. Харин тэдгээр орд нь хэр том орд болох, ямар ашигтай ажиллаж байгаа зэрэг нь өөр асуудал билээ.

Компанийн нэр	Лицензийн төрөл	Ашиглалтын лицензийн байршил 2010 оны 8-р сарын байдлаар ⁴	Төлсөн татвар /2008 оны тайлангаар/	Лицензийн төлбөр
Ì í òðèòì ò ХХК	жонш	Дорноговь, Алтанширээ	00 төг	17,761,000 төг
Ýí ãçéòàè ХХК	Алт Нүүрс	Баянхонгор, Шинэжинст Сүхбаатар		
Ýðòýñ ì àéí èí ã ХХК	Алт	Булган, Бүрэгхангай Дархан-Уул, Хонгор Сэлэнгэ, Орхон туул Төв, Заамар		
Äóí -Ýðäýí ý ХХК	Алт	Дорнод, Баяндун		
ÀØÁ ХХК	Алт	Төв, Заамар		
Áàðèèäà-Î ðä ХХК	Алт Барилгын материал	Дархан-Уул, Хонгор Улаанбаатар, Сонгинохайрхан		
Ì ÁÄÖ ХХК	Алт	Баянхонгор, Гурванбулаг		
Õóí àí ХХК	Алт	Төв, Сэргэлэн		

Эдгээр компанийн зарим нь энд тэнд морь, бөх ивээн тэтгэж явдагаараа нэр танил байлаа. Энэ жишээнд зөвхөн хайгуулын лицензтэй түүнийхээ төлбөрийг төлдөг, харин ямар нэг олборлолт хийдэггүй компаниуд ороогүй байгаа болно.

Тэднээс гадна жилдээ 10.000–50.000 төгрөгийн татвар төлсөн Гэрэлт-Од, Арвин хад, Баялаг газар, Эж-эрдэнэ, Булган-Инвест, Аниш зэрэг компаниуд бүгд ямар нэг лиценз эзэмшиж байна.


Олон лицензтэй тусмаа их татвар төлдөг үү?

Уул нь их баялаг, том газар лиценз хэлбэрээр авсан байх тусмаа төлдөг татвар нь их байх болов уу гэж хар ухаанаар бодмоор. Гэвч төлсөн татвар, лицензийн төлбөр гэсэн хоёр үзүүлэлтийг тайланд хамрагдсан компаниудын хувьд харилцан хамаарлыг нь бодоод үзвэл

⁴ Эх сурвалж: АМГТХЭГ

Корреляционный коэффициент = 0.11 гэж гарч байна. Өөрөөр хэлбэл их лицензтэй тусмаа их татвар төлнө гэсэн таамаглал статистикаар батлагдахгүй байгаа бөгөөд энэ хоёр үзүүлэлтийн хооронд маш сул буюу хамаарал бараг байхгүй байна.

Үүний хамгийн тод жишээ нь Эрдэнэт үйлдвэр. Тус компани эзэмшиж буй лицензийн талбайгаараа эхний 5-д орохгүй бөгөөд төлж буй лицензийн төлбөр нь дундаж компаниудтай ойролцоо боловч улсад төлж буй татвараараа хэнтэй харьцуулашгүй өндөр байгаа юм. Эсрэгээрээ их хэмжээний талбай, олон лиценз эзэмшдэг боловч өчүүхэн бага татвар төлдөг компаниудыг доорх хүснэгт болон лицензийн төлбөр, татварын харьцааг харуулсан тархалтын зургаас тод харж болно.



Лицензийн төлбөрөөр манлайлагчид буюу хамгийн их лиценз эзэмшигчид тэдний төлсөн татвар	Компани	Лицензийн төлбөр 2008 онд /мянган төг/	Тухайн онд төлсөн татвар /мянган төг/
1	Айвенхоу Майнз Монголиа	2,612,760,0	828,983.20
2	Āī áè êī óë ýí ä ýí äðæè	1,470,600.0	114,168.50
3	Òàòèñ ì àéí èí ã	913,296.0	120,142.80
4	Äàì áàò	702,777.5	

Харин Засгийн газар 2007 онд 1 тэрбум 843 сая, 2008 онд 1 тэрбум 57 сая төгрөгийн хандив тусламжийг уул уурхайн компаниудаас хүлээн авсан гэж мэдүүлээд байна. Тодорхой компани дээр харвал хандив тусламж их өгдөг гэж пиарддаг “Бороо гоулд”-аас ямар нэг хандив, тусламж авсан гэж Засгийн газар мэдүүлээгүй байгаа нь сонирхолтой. Дорнодын талаас уран олборлохоор хөөцөлдөж, Монгол улсын Засгийн газартай шүүхдэлцэж байгаа “Төв азийн уран” компани 300 мянган төг өгсөн, авсан гэж нотлогдож байгаа нь огт ямар нэг тооцоо байхгүй “Алтандорнод”, “Цайрт минералз”, “Болд төмөр ерөө гол”, “Шижир алт”, “Чинхуа мак нарийн сухайт”, “Монполимет”, “Тацуурт”, “Петрочайна дачин тамсаг” зэрэг том том компаниудаас арай дөнгүүр ч юм шиг.

Боловсруулсан:
ИНФОРУМ ТӨВ
А.Батпүрэв